

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН “ОЮУТОЛГОЙ БҮЛЭГ ОРДЫН АШИГЛАЛТАД  
МОНГОЛ УЛСЫН ЭРХ АШГИЙГ ХАНГУУЛАХ, ХҮРТЭХ ӨГӨӨЖИЙГ  
НЭМЭГДҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ БАРИМТ БИЧИГ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД  
ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ” ҮҮРЭГ БҮХИЙ ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРОНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

**2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр, Лхагва гараг**

**Хуралдааны тэмдэглэлийн агуулга**

**Хуралдааны товч тэмдэглэл:** 1

**Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:** 2-3

---

**Нээлттэй хуралдаан** 2-3

**Монгол Улсын Их Хурлын “Оюутолгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх” үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны 2025 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр /Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хянан шалгах түр хорооны дарга О.Батнайрамдал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр нээлттэй хуралдаан 11 цаг 31 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

*Томилолттой: Б.Бат-Эрдэнэ, Ш.Бямбасүрэн.*

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, Хяналт шалгалтын газрын референт Д.Мөнхтуяа, ахлах мэргэжилтэн С.Сэргэлэн, мөн газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Д.Гэрэлт-Од нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийг үндэслэн Түр хорооны дарга О.Батнайрамдал хуралдаанаар хэлэлцэх асуудлыг хаалттай хэлэлцэх горимын санал гаргав.

**О.Батнайрамдал:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 0  
Бүгд: 6  
100 хувийн саналаар дэмжигдлээ.

*Нээлттэй хуралдаан 03 минут үргэлжилж, 11 цаг 34 минутад хаалттай горимд шилжив.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ ДАРГА

О.БАТНАЙРАМДАЛ

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр,  
Лхагва гараг  
Төрийн ордон “Их засаг” танхим  
11 цаг 31 минут.

### **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН “ОЮУТОЛГОЙ БҮЛЭГ ОРДЫН АШИГЛАЛТАД МОНГОЛ УЛСЫН ЭРХ АШГИЙГ ХАНГУУЛАХ, ХҮРТЭХ ӨГӨӨЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ БАРИМТ БИЧИГ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ” ҮҮРЭГ БҮХИЙ ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**О.Батнайрамдал:** Эрхэм Хянан шалгах түр хорооны гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Оюутолгой бүлэг ордын ашиглалтын асуудлаарх Хянан шалгах түр хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул 2025 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Хуралдаанд хүрэлцэн ирсэн гишүүдийн ирцийг танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Өлзийхүүгийн Шижир, Пүрэвжавын Ганзориг, Сархадын Зулпхар, Баярмагнайн Баярбаатар, Батбаярын Батжаргалан, Отгоншарын Батнайрамдал гэсэн ирцээр ирц би юу гэххэв? Батбаярын Жаргалан. Нээрээ юу? Уучлаарай андуурч хэлсэн бол уучлаарай. Батбаярын Жаргалан гишүүн хүрэлцэн ирснээр 54.5-тай ирц бүрэлдсэн байна.

Өнөөдрийн хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцэнэ. Үүнд:

Хянан шалгах түр хорооны шинжээчийг танилцуулж, томилох тогтоолын төслийг хэлэлцэх нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Хянан шалгах түр хорооны хянан шалгах шинжээчдийн ажлын удирдамжийг хэлэлцэж батлах.

Гуравдугаарт, Оюутолгой төслийн үйл ажиллагааны талаар “Эрдэнэс Оюу толгой” хариуцлагатай ХК-ийн танилцуулга, мэдээллийг сонсох гэсэн 3 асуудлууд байна.

Хэлэлцэх асуудлын талаар өөр саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Хянан шалгах түр хорооны шинжээчийн, өнөөдрийн хэлэлцэх эхний асуудал Түр хорооны шинжээчийг томилох нь Хянан шалгах түр хорооны дотоод асуудал бөгөөд Хянан шалгах түр хорооноос томилогдон ажиллахад шинжээчид хөндлөнгөөс нөлөөлөх магадлалтай. Мөн “Эрдэнэс Оюу толгой” болон “Онтрэ” хариуцлагатай ХК-ийн асуудлаарх Түр хорооноос авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар нарийвчилсан мэдээллийг хийх учраас хаалттай явах хуралдааны горимын саналыг гаргаж байна.

Тэгэхээр гишүүд ээ шинжээчийг томилох тэгээд “Эрдэнэс Оюу толгой”-н мэдээллийг сонсох дээр хаалттай горимоор явуулъя гэсэн горимын саналыг гаргаж

байгаа юм. Та бүхэн сонсов уу хоёр асуудлаар? Тэгэхээр иймд Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийг үндэслэн хуралдааныг хаалттай горимд шилжүүлэх горимын саналаар санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлдэнэ үү.

Бэлэн. Санал хураалт.

Нийт хуралдаанд оролцсон гишүүдийн 100 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ. Хуралдааныг хаалттай горимд шилжүүлнэ үү.

11.34 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

*Д.ОТГОНДЭЛГЭР*